Тохойн гадна хажуугийн шөрмөсний үрэвслийн үеийн ясны бариа заслын эмчилгээний үр дүн

Жин Ай Хуа[1], Б.Бадамцэрэн[1], Э.Амарзаяа[1], Ба Ху Шан[2], Уудам[1], Тана[3], З.Болортулга[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт эмчилгээний тэнхим
[2]БНХАУ,ӨМӨЗО,Олон Улсын Эмнэлгийн Хороо ясны тасаг
[3]БНХАУ,ӨМӨЗО,Олон Улсын Эмнэлгийн Хороо таван засал сэргээн засах тасаг
Цахим шуудан:amd22e045@gt.mnums.edu.mn, Утас: 88764257

Түлхүүр үг:

Теннис тохой
Уламжлалт
ясны
бариа засал
Шөрмөс

Товч утга

Үндэслэл: Тохойн үений атгаалын гадна хажуугийн үрэвсэл бол бугуйн үений нугалах, сунгах хөдөлгөөний давтагдах ачааллын улмаас humeral epicondyle шөрмөс нь гэмтэж, тохойн үений гадна хажуугийн булчин шөрмөсний хэсэгт өвдөлтөөр тодорхойлогдон “Теннис тохой” нэр бүхий, олон улсын өвчний 10-р ангилалд (ICD-10) M77.01-т хамааруулан ангилсан байна. Хүн амын 1- 3% нь өвчилж,сүүлийн жилд 4.3%-5.5%-аар нэмэгдэж байна. Тус эмгэгт мэс заслын бус гаж нөлөө багатай, стандарт эмчилгээ тодорхойгүй ч үйлчлүүлэгчийн сонирхлын дагуу бариа заслын эмчилгээг өргөн хэрэглэгдсээр ирсэн. Уламжлалт ясны бариа засал нь монгол хүний авьяас ур ухаанаар бий болсон эмчилгээний хамгийн сайн туршлагат, бие махбодод гэмтэл учруулдаггүй, гарын мэдрэмжээр эмчилдэг noninvasive арга юм. Монголчуудын дэлхийн анагаах ухааны хөгжилд оруулсан олон эмчилгээний аргуудын нэг нь монгол ясны бариа заслын арга юм. **Зорилго:** Тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвслийн үеийн уламжлалт ясны бариа засал эмчилгээний үзүүлэх нөлөөг судлах. **Арга, аргачлал:** Тус судалгааг АШУҮИС, МАУҮТЭмнэлгийн өдрийн эмчилгээний тасаг, Өвөр Монголын Олон Улсын Эмнэлгийн хорооны ясны тасагт түшиглэн эмнэл зүйн санамсаргүй хяналтат туршилт судалгааны аргаар 30 эмчлүүлэгч хамруулан,эмчилгээний бүлэгт хар архин бариа засал, хяналтын бүлэгт дасгал хөдөлгөөнийг 10 удаа хийж гүйцэтгэв. Тохойн өвдөлтийг (Patient-Rated Tennis Elbow Evaluation 2010) үнэлэх асуумж, Оксфордын тохойн онооны үнэлгээг ашиглан эмчилгээний үр дүнг дүгнэв. **Үр дүн:** Бидний судалгаанд тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл оношбүхий 30 өвчтөн хамруулахад дундаж нас 49.5±8.5, эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа 14:16 байв. Уламжлалт ясны бариа засал нь тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвслийн өвдөлтийг PRTEE оноо 51.9-ээс 13.8 (хамгийн сайн оноо 0, хамгийн муу оноо 100) бүхий ач холбогдолтой бууруулж, тохойн хөдөлгөөний үйл ажиллагааны оксфордын тохойн оноогоор өвдөлтийг 45.4-аас 91.1; тохойн хөдөлгөөний үйл ажиллагаа 27.5-аас 90.7; нийгэм-сэтгэл зүй 37.5-аас 94.6 (хамгийн сайн оноо 100, хамгийн муу оноо 0) бүхий тохойн өвдөлтийг бууруулж, хөдөлгөөний идэвхийг сайжруулсан үр дүнтэй байв. **Дүгнэлт:** Тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвслийн хөнгөн, дунд зэргийн үед уламжлалт ясны бариа засал тохойн өвдөлтийг бууруулж, хөдөлгөөний идэвхийг сайжруулан эмчилгээний үр дүн өндөртэй байна.

Үндэслэл: Тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл нь тохойн үений нугалах, тэнийлгэх, давтагдах хөдөлгөөний ачааллын улмаас humeral epicondyle шөрмөс нь гэмтэж, өвдөлтийн шинж тэмдгээр илэрдэг Lateral epicondylitis of elbow (ICD-10) M77.1 оношбүхий эмгэг юм.[1] Хүн амын 1- 3%[2] нь энэ өвчнөөр өвчилдөг боловч 2022 оны байдлаар 4.3%-5.5% болж өсөн нэмэгдэж байна. Ихэвчлэн 30-64 насны хүмүүст, шуугаа олон удаа сунгах хөдөлгөөн хийдэг теннис, волейбол, гандбол, бейсбол, жад шидэлтийн тамирчид, аж үйлдвэрийн ажилтан, зураач, сантехникч, мужаан, бичээч, компьютер дээр ажилладаг мэргэжлийн хүмүүст тохиолддог. Гар, бугуй шууны хэсэгт өвдөлт дамжин тархаж, тайван үед ч өвдөлт мэдрэгдэж, амьдралын чанарт муугаар нөлөөлдөг эмгэг юм. Likewise, Solheim нарын судалгаагаар уг өвчний үед дуран, нээлттэй мэс заслын эмчилгээ хийлгэсэн өвчтөнүүдийн 67%- 78%

нь үр дүнтэй гэсэн байна. Тохойн атгаалын хажуугийн шөрмөсийг эмчлэх стандарт эмчилгээ тодорхойгүй, мэс заслын бус эмчилгээ нь эмчилгээний гол суурь хэвээр байна. Монгол анагаах ухааны хар архиар шүршиж барих эмчилгээний арга нь Монгол хүний амьдралын хэв маяг,ур ухаанаар бий болсон хамгийн сайн туршлагат (best practice), хүний биед гэмтэл учруулдаггүй гарын мэдрэмжээр эмчилдэг noninvasive арга юм. Монголчуудын дэлхийн анагаах ухааны хөгжилд оруулсан эмчилгээний аргуудын нэг нь ясны бариа заслын төрөл хар архиар шүршиж барих арга юм.[3] XIII-XIV зууны үеэс "Монголын нууц товчоо", "Алтан товч" "Юань улсын түүх" зэрэг монголын түүхийн гол сурвалж бичгүүдэд Монголчууд тархины доргилтыг барих, яс барих талаар гарамгай мэргэшсэн төдийгүй Юань улсын үед бариа заслын хэд хэдэн эмнэлэг сургууль байгуулагдан ажиллаж байсан тухай тэмдэглэгдсэн байна.[4] Сүүлийн үед хүн ард суурьшмал амьдралын хэв маягт шилжсэнээр хөдөлгөөний хомсдол үүсэж, ухаалаг технологийн хэрэглээ ихэссэн нь тохойн үений эмгэгийг нэмэгдүүлэх гол шалтгаан юм. Мэс заслын бус, гаж нөлөө багатай эмчилгээний аргаар эмчлүүлэх үйлчлүүлэгчийн сонирхлын дагуу бариа засал өргөн хэрэглэгдэж ирсэн байна. Гэвч тохойн атгаалын гадна шөрмөсний үрэвсэлд уламжлалт архиар шүршиж барих эмчилгээний үр дүнг тооцсон судалгааны ажил хараахан хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болно.

Зорилго: Тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэлд уламжлалт архиар шүршиж барих ясны бариа заслын эмчилгээний үр дүнг судлахад оршино.

Зорилт:

1. Уламжлалт бариа заслын тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвслийн өвдөлтийг бууруулах нөлөөг судлах
2. Тохойн үе, бугуйн хөдөлгөөний үйл ажиллагааны алдагдалд хар архиар шүршиж барих бариа засал үзүүлэх нөлөөг судлах
3. Үйлчлүүлэгчийн өдөр тутмын амьдралын чанар, сэтгэл зүйн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг судлах


Арга, аргачлал: Уг судалгааг АШУҮИС-ийн МАУТЭмнэлэг, Өвөр Монголын Өөртөө засах орны Олон Улсын Монгол Эмнэлгийн Хорооны эмнэлгийн өдрийн эмчилгээний тасагт түшиглэн явуулав. Судалгаанд хамрагдах шалгуурыг хангасан таниулах зөвшөөрлийн хуудсаар зөвшөөрсөн 30 үйлчлүүлэгчийг сонгон хамруулсан АШУҮИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны 2024оны 01 сарын 19-ны (№ А/3-01) хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсан. Компьютерын цахим программ ашиглан, санамсаргүй түүврийн аргаар уламжлалт бариа засал эмчилгээний бүлэг (n=15), хяналтын бүлэг (n=15) гэсэн 2 бүлэгт хуваааж санамсаргүй хяналтат туршилт , судалгааны дан нууцлалын аргаар явуулав. Эмчилгээний бүлэгт хар архиар шүршиж барих бариа засал, хяналтын бүлэгт гарын дасгал хөдөлгөөнийг мэргэжлийн хөдөлгөөн засалчийн хяналтаар 7хоногт 5 удаа нийт 10 удаа хийж, гэрээр бие дааж хийх зааварчилгааг өгсөн. Судалгааны үр дүнг тооцохдоо тохойн шөрмөсний үрэвслийн өвдөлтийг өөрөө үнэлэхPRTEE(Patient-Rated Tennis Elbow Evaluation 2010), тохой бугуйн үйл ажиллагааны алдагдлыг үнэлэх Оксфордын тохойн оноо (Oxford Elbow Score (OES) 2016), гарын атгах хүчийг динамометр багажаар хэмжиж, эмчилгээний өмнө, эмчилгээний дараа, эмчилгээ хийгдсэнээс 1сарын дараах үр дүнг харьцуулан дүгнэв. Мөн тохойн үений хэт авиа оношилгоонд Philips iU 22 эхо багажийг ашиглаж, өндөр давтамжийн шугаман датчик, 8~15 MHZ давтамж бүхий өнгөт допплерт хэт авиа шинжилгээгээр тохойн гадна хажуугийн шөрмөс, тохойн хажуугийн яс, булчинг босоо хөндлөн чиглэлд үрэвсэл хаванг тодорхойлж үнэлсэн.[5]

Үр дүн: Бидний судалгаанд хамрагдсан нийт 30 үйлчлүүлэгчдийн хувьд эмчилгээний бүлэгт эрэгтэй n=8(53%), эмэгтэй n=7(47%), дундаж нас 49.6±9.4 жил байв. Харин хяналтын бүлэгт эрэгтэй n=6(43%), эмэгтэй n=8(57%) дундаж нас49±8 жил, эмчилгээний бүлэгт зүүн тохой 5 (33%), баруун тохой 10(67%) , хяналтын бүлэгт зүүн тохой 4 (26%), баруун тохой 11(74%) тохиолдсон байв. Хоёр бүлгийн хооронд нас хүйсний ялгаа илрээгүй байна. (p>0.05). (хүснэгт1)

Хүснэгт 1. Үйлчлүүлэгчдийн нас хүйсийн харьцуулсан үр дүн


Бүлэг	Хүйс		P утга	Дундаж нас	P утга	Тохойн байрлал		P утга
	Эрэгтэй	Эмэгтэй				Баруун	зүүн	
Эмчилгээний бүлэг	8 (53%)	7 (47%)	1	49.6±9.4	0.95	10(67%)	5(33%)	0.69
Хяналтын бүлэг	7 (47%)	8 (53%)		49 ± 8.1		11(74%)	4(26%)	

Эмчилгээний өмнө тохойн гадна хажуугийн шөрмөсний өвдөлтийг өөрөө үнэлсэн үнэлгээгээр (PRTEE) эмчилгээний бүлэгт 28.7±2.79, хяналтын бүлэгт 28.73±2.22 тодорхойлсон нь хоёр бүлэгт ойролцоо хуваарилагдсан байв. Эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт 9.40±3.22, хяналтын бүлэгт 17.13±7.71, нэг сарын дараах үр дүнд эмчилгээний бүлэгт 6.66±2.87, хяналтын бүлэгт15.20±7.04 болж өвдөлт буурсан байна. Эмчилгээний дараа болон нэг сарын дараах эмчилгээний бүлэг, хяналтын бүлэгт тохой үений шөрмөсний өвдөлтийг өөрөө үнэлэхэд (PRTEE) статистик ач холбогдол бүхий буурсан ялгаатай байлаа (p<0.05) (зураг1).




Зураг 1. Тохойн гадна хажуугийн шөрмөсний өвдөлтийг өөрөө үнэлсэн (PRTEE) үр дүн

Oxford elbow score (OES) өвдөлтийн оноогоор (0-100 оноо их утга нь үр дүн сайн)эмчилгээний бүлэгт эмчилгээний өмнө 45.41±8.68, хяналтын бүлэгт 37.47±8.81, эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт 86.8±4.8, хяналтын бүлэгт 64.17±20.25, нэг сарын дараа эмчилгээний бүлэгт 91.25±3.06, хяналтын бүлэгт 71.67±20.03 болж нэмэгдэн өвдөлтийг багасгасан байна. Эмчилгээний бүлэг, хяналтын бүлэгт Oxford elbow score (OES) өвдөлтийн оноо нь статистик ач холбогдол бүхий ялгаатай өвдөлтийг бууруулсан байна.(p<0.05). (Зураг 2)



Зураг 2. Oxford elbow score тохойн өвдөлтийн оноогоор үнэлсэн үр дүн


Тохойн хөдөлгөөний үйл ажиллагааны чадвар алдалт өөрөө (PRTEE) үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 31.60±6.5, хяналтын бүлэгт 31.53±1.32, эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт 10.22±2.97, хяналтын бүлэгт 17.73±9.34, нэг сарын дараа эмчилгээний бүлэгт 8.23±2.90, хяналтын бүлэгт 14.33±7.44 болж буурч, сайжирсан ба эмчилгээний бүлэг, хяналтын бүлэгт тохойн үйл ажиллагааны чадвар алдалт статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. (p<0.05). (Зураг 3)



Зураг 3 Тохойн хөдөлгөөний үйл ажиллагааны чадвар алдалтыг өөрөө үнэлсэн үр дүн(PRTEE)

Oxford elbow score (OES) Тохойн үений хөдөлгөөний үйл ажиллагааг үнэлэхэд эмчилгээний өмнө эмчилгээний бүлэг 27.50±9.63, хяналтын бүлэгт 27.08±6.54, эмчилгээний дараа эмчилгээний бүлэг 87.48±3.87, хяналтын бүлэг 63.32±23.96, нэг сарын дараа эмчилгээний бүлэг 90.84±5.03, хяналтын бүлэг 70.83±20.55 болж тус тус нэмэгдсэн. Эмчилгээний дараа хоёр бүлэгт тохойн хөдөлгөөний үйл ажиллагаа нь статистик ач холбогдолтой нэмэгдсэн байна (p<0.05). (Зураг 4)

Гарын атгах хүчийг үнэлэхэд эмчилгээний өмнө хяналтын бүлэгт 18.43±5.55кг, эмчилгээний бүлэгт 19.51±4.00кг, эмчилгээний дараа хяналтын бүлэгт 27.15±5.12кг, эмчилгээний бүлэгт 31.25± 6.78кг, нэг сарын дараа хяналтын бүлэгт 29.76±4.92кг, эмчилгээний бүлэгт 33.07±7.13кг болж тус тус нэмэгдсэн.




Зураг 4 Oxford elbow score Тохойн үений хөдөлгөөний үйл ажиллагааг үнэлсэн үр дүн

Эмчилгээний дараа болон нэг сарын дараа эмчилгээний бүлэг, хяналтын бүлэг гарын атгах хүч нь статистик ач холбогдолтой нэмэгдсэн байна (p<0.05). (Зураг 5)



Зураг 5 Гарын атгах хүч (динамометрийн хэмжилтийн үр дүн

Oxford elbow score оноогоор нийгэм-сэтгэл зүйн амьдралын чанарын үнэлгээгээр эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт 37.5±8.5, хяналтын бүлэг 34.3±3.9, эмчилгээний дараа эмчилгээний бүлэгт 88.7±6.3, хяналтын бүлэг 68.7±19.9, нэг сарын дараа эмчилгээний бүлэг 91.2±5.1, хяналтын бүлэг 70.8±20.5 тус тус нэмэгдсэн байлаа.(Зураг 6)



Зураг 6 Oxford elbow score (OES) амьдралын чанарын үнэлсэн үр дүн

Хэт авиа оношилгоонд: Эмчилгээний өмнө тохойн үений гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл нь тохойн үений гадна хажуугийн шөрмөсний суналт 9,5х5,3мм, хэсэг газрын хавантай, хар архин бариа заслын эмчилгээний дараа шөрмөсний суналт 4,7х3,0 мм болж багасаж, хаван буурсан байна.

Хэлцэмж: Монгол анагаах ухааны бариа заслын архи шүршиж барих арга нь хий, цусны эргэлтийг сайжруулж, мэдрэлийг сэргээн идэвхжүүлж, өвдөлттэй хэсгийн өвдөлтийг багасгах, булчин шөрмөсийг суллаж, зөөлрүүлж, агшилтыг суллаж тайвшруулах, бодисын солилцоог нэмэгдүүлэх, зөөлөн эдийн эдгэрэлтийг түргэсгэх, эд эсийг нөхөн төлжилтийг дэмжих, өвдөлтийг намдаах, зовуурийг багасгах зорилготой. Архи шүрших нь агаарын

даралтаар олон мянган цацраг усан дусал хэлбэрээр биеийн гэмтсэн хэсэгт даралттай хүрэлцсэнээр арьсны гадаргууд хүчтэй цочроох, захын хэсгийн мэдрэлийг сэргээж, хөлсний нүх, хялгасан судсанд гүн нэвтэрч, мэдрэл, шөрмөсийг цочроосноор гэмтэлтэй хэсэгт эс эдийн зөөлөн эдийн эмгэгийн үйл ажиллагааг сэргээн эдгэрэлтийг нэмэгдүүлдэг. Мөн хүний оюун санааны өвдөлтийн сэрлийг сарниулж, өвдөлтийг намдаах үйлчилгээтэй.[6] Бидний судалгаанд хамрагдсан нийт 30 үйлчлүүлэгчдийн дундаж нас 49.6±8.5 жил баруун тохойн үений шөрмөсний үрэвсэл их тохиолдож байлаа. Энэ нь судлаач Yumei Zhou, Yuebao Guo, Zhuoxin Yang- нарын[7] 796 оролцогчид хамруулсан бөгөөд дундаж нас 44.56-52.5 жил гэсэн үр дүнтэй ойролцоо байна. Судлаачид Ли Вэй ян, ши Чен Пин нарын[8] тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэлд Tennis elbow eccentric training plus joint loosening treatment дасгал эмчилгээний судалгаанд дундаж нас 43.4±10.3 жил, зүүн тохой 17(42.5%), баруун тохой 23(57.5%), эрэгтэй 26 (65%), эмэгтэй 14(35% хамрагдаж, эмчилгээний өмнө эмчилгээний бүлэгт PRTEE өвдөлтийн оноо 35.5±6, үйл ажиллагааны оноо 68.67±12.59, гарын атгах хүч 18.2±3.97кг байсан. Эмчилгээний дараа өвдөлтийн оноо 6.8±3.91. үйл ажиллагааны оноо 12.56±4.46, гарын хүч 29.59±5.62кг үр дүн илэрхийлсэн нь бидний судалгааны уламжлалт хар архиар шүрших бариа заслын эмчилгээний үр дүнтэй харьцуулахад дундаж нас 49.6±8.5 жил, зүүн тохой 9(30%) баруун тохой 21(70%) байгаа нь баруун тохойн үений шөрмөсний эмгэг нь харьцангуй их тохиолддог болохыг тодруулав. PRTEE өвдөлтийн оноо бидний судалгаанд эмчилгээний бүлэгт 6.66±2.87, тохойн хөдөлгөөний үйл ажиллагааны чадвар алдалт өөрөө (PRTEE) үнэлэх оноо 8.23±2.90 болж өвдөлт намдаж, үйл ажиллагааны алдагдалд уламжлалт ясны бариа заслын үр дүн өндөртэй болохыг харуулж байна. гарын атгах хүч нэмэгдэж байв. Судалгааны үр дүнгээр тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэлд уламжлалт хар архиар шүрших барих бариа засал нь статистик магадлал бүхий ялгаатай сэргээн засах дасгалын бүлгээс илүү үр дүнтэй болохыг тогтоосон. (P<0.05). Монголын уламжлалт анагаах ухаанд хар архин бариа заслын “архи шүршиж” иллэг хийх аргаар тохойн үений атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвслийг эмчлэхэд бусад эмчилгээний аргуудтай харьцуулахад аюулгүй, гаж нөлөөгүй, хүндрэлгүй, эмчилгээний үр дүн өндөртэй, эмчлүүлэгчид таатай мэдрэмж төрүүлдэг өвдөлтгүй, зардал багатай тул эмнэл зүйд нэвтрүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт: Тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэлд уламжлалт хар архиар шүршиж бариа засал нь өвдөлтийг намдааж, тохойн хөдөлгөөний үйл ажиллагааг сайжруулан, гарын атгах хүчийг нэмэгдүүлж, өвчтөний нийгэм-сэтгэл зүйн байдал мэдэгдэхүйц эерэг нөлөө үзүүлж байна. Мөн тохойн атгаалын гадна хажуугийн шөрмөсний үрэвсэл эмгэгт уламжлалт хар архиар шүршиж бариа засал эмчилгээ нь хөдөлгөөн засал эмчилгээнээс үр дүн өндөртэй болохыг нотлов.

Талархал: Судалгааг хийхэд тусалж дэмжсэн судалгааны ажлын удирдагч АУ-ны доктор, дэд профессор З.Болортулга, АШУҮИС, МАУОУСургуулийн багш нар, МАУТЭмнэлгийн хамт олон, Өвөр Монголын Хөх хотын Олон Улсын Эмнэлгийн хорооны яс, гэмтлийн тасгийн хамт олондоо гүнээ талархал илэрхийлье.

Ном зүй:

1. International Statistical Classification of Diseases and Related Health Problems (ICD-10) 2015

2. Verhaar JA. Tennis elbow: anatomical, epidemiological and therapeutic aspects. Int Orthop. 1994;18(5):263–267.

3. The Mongolian Observer, D.Tserendagva 2015).

4. Н.Төмөрбаатар. Монголчуудын дорно дахины анагаах ухаанд оруулсан зарим хувь нэмэр. Монголын анагаах ухаан сэтгүүл. 2010 ;1:151-154

5. 傅先水，张卫光．肌骨关节系统超声检查规范．北京：人民军医出 版社，2008: 64—65．

6. Бао Жиньшань 1, Бао Жаньхун 2; Баогийн монгол ясны эмгэг - 5000 гаруй жилийн өмнөх бэлчээрийн соёлын өв залгамжлал, хөгжил; Ази-Номхон далайн уламжлалт анагаах ухаан; 12-р сар. 2018 Vbl. 14ҮГҮЙ. 12

7. Yumei Zhou, Yuebao Guo, Zhuoxin Yang- “Effectiveness of Acupuncture for Lateral Epicondylitis: A Systematic Review and Meta-Analysis of Randomized Controlled Trials

8. 黎维赕、奚陈平、张伟伟、刘阳、刘晓林．动态关节松动术结合离心训练对肱骨外上髁炎的疗效观察 ．中国康复． 2024 ．4 ：218-210

The effect of traditional Mongolian bone massage therapy on pain of lateral epicondylitis tennis elbow

Jin Ai Hua[2] ,Badamtseren B[1], BaHuShan[1] , WuDaMu1 , Tana[1] Amarzaya[1], Tserenkhand Ch[1], Bolortulga Z[2]

[1]Acupuncturist, ISMM, MNUMS 601 part
[2]Department of Traditional Therapy, ISMM, MNUMS
Email:tam18d007@st.mnums.edu.mn, Tel:976-88764257

Background: Lateral epicondylitis of the elbow grip is a disorder with the diagnosis M77.01, when the humeral epicondyle tendon is damaged and painful due to the movement load of the elbow joint (ICD-10). 1-3% of the population is sick, and it is increasing by 4.3%-5.5% in the last year. Traditional bone massage therapy is a noninvasive treatment method created by the talent of Mongolian people without side effects and treated by the feeling of the hand.
Aim: To study the effects of traditional bone massage therapy on pain in the external lateral ligament of the elbow joint (lateral epicondylitis)
Materials and Methods: The study was conducted by the MNUMS, Central Hospital of Mongolian Traditional Medicine, In the trauma department of Inner Mongolia International Hospital 30 patients were included in the clinical randomized controlled trial research method, the treatment group performed alcohol mongolian massage and the control group performed movement exercises 10 times. Treatment outcomes were evaluated using the PRTEE questionnaire and the Oxford Elbow Score.
Results: Our research included 30 patients with an average age of 51, and the male-to-female ratio was 10:5. Traditional bone massage therapy showed a significant reduction in inflammatory pain of the elbow joint humerus bone external lateral ligament inflammatory pain showed a significant improvement in PRTEE scores from 51.9 to 13.8, with (the best score being 0 and the worst score being 100). There was also a significant improvement in elbow movement activity based on the Oxford elbow points, with pain scores decreasing from 45.4 to 91.1 and elbow activity scores increasing from 27.5 to 90.7. The socio-psychology scores improved from 37.5 to 94.6 (the best score is 100 and the worst score is 0), indicating a reduction in elbow pain and an improvement in movement activity. The cure rate was 75.5%, with 20% showing improvement and 4.5% experiencing a slower healing process.
Conclusion: In cases of elbow joint lateral epicondylitis of elbow, traditional mongolian bone massage therapy has shown to be effective in reducing elbow pain, improving movement activity, and providing an effective treatment option in clinical practice.

Keywords: Lateral epicondylitis of elbow, tradinational, tendons